



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 4 сарын 4 өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах  
тухай


Төсвийн тухай хуулийн 11.1.2, 46.5 дахь хэсгийг тус тус үндэслэн  
ТУШААХ нь:

Нэг. Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 238 дугаар  
тушаалаар батлагдсан “Төсвийн урамшуулал олгох хувь, хэмжээ, шалгуур  
үзүүлэлт, түүнийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт  
тавих журам”-ын 4 дэх хэсэгт дор дурдсан агуулга бүхий заалт нэмсүгэй:

“4.11. Урамшууллын 70-аас доошгүй хувийг энэ журмын 4.10.1-д заасан  
зориулалтаар зарцуулна.”

Хоёр. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого,  
төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/, Аймаг,  
нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсүүдэд тус тус үүрэг болгосугай.

САЙД



Ч.УЛААН